

Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн, Бүрэнбаатар Лхамжав

2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
<p>1.1. Салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж, сайдын болон дээд шатны байгууллагаас ирүүлсэн шийдвэрийн хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих, салбарын хуулийн төсөл боловсруулах, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судалж арилгах, хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, яамны үйл ажиллагааны хүрээнд сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргын гаргах шийдвэр болон яамны зүгээс бусад байгууллагатай харилцах, гэрээ байгуулахад эрх зүйн үндэслэлийг хангуулах, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэгээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих;</p>							
1	Сайдын тушаалаар батлагдсан төсөл, арга хэмжээг ТХААГ-аас тендер сонгон шалгаруулалтад шалгарсан этгээдтэй Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулна.	Гүйцэтгэлийн явц, хувиар	-	Зөвлөх үйлчилгээний гэрээ тухай бүр байна./100 хувь/	Сайдын тушаалаар батлагдсан ТХААГ-аас тендер шалгаруулалтад оролцсон 8 төсөлд Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах эрх олгогдсон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2 дахь заалтад заасан хугацаанд зарим гэрээ байгуулагдаагүй тул тухайн төсөв татагдсан болно. Тус хугацаанд багтсан төслөөс Увс аймгийн Улаангом сум доторх инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ТЭЗҮ, зураг төсөв хэрэгжүүлэхээр	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>Гидродизайн ХХК, Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны өргөтгөлийн зураг төсөв /Увс аймаг/ хэрэгжүүлэхээр Гобитравэл ХХК-иуд шалгарч, зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан байна. Гидродизайн ХХК нь явцын тайланг хүлээлгэн өгч нийт санхүүжилтийн 30 хувийг авсан байна. Мөн тус гэрээнд өөрчлөлт оруулж гэрээний хугацааг 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр хүртэл сунгахаар гэрээний төслийг боловсруулан албажуулахаар хүлээгдэж байна. Гобитравэл ХХК нь мөн адил эхний санхүүжилтийг авсан ба гэрээнд өөрчлөлт оруулан гэрээт ажлын хугацааг 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хүртэл сунгасан. Мөн 2024 онд хэрэгжиж эхэлсэн ч тухайн улиралд багтаж дуусаагүй төслүүдээс 2025 онд "Алтанбулаг чөлөөт бүс доторх 13.8 км авто зам, чөлөөт бүсээс хил хүртэлх хүзүүвчний хэсгийн 0.81 км авто замын зураг төсөл/Сэлэнгэ, Алтанбулаг сум/", "Бага газрын аялал жуулчлалын бүсийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл /Дундговь, Дэлгэрцогт сум/" төслүүдийн зураг төсөв дуусаж гүйцэтгэгч компаниуд</p>		
--	--	--	--	--	---	--	--

					үлдэгдэл санхүүжилтыг бүрэн авч дууссан. 2024 онд хэрэгжиж эхэлсэн "Сургуулийн барилгын жишиг нэг маягийн зураг төсөв, 320 суудал /улсын хэмжээнд", "Сургуулийн спорт заалны их засварын зураг төсөв, төсөл /Увс, Баруунтуруун сум/ зураг төсвүүд дуусаж санхүүжилт авах шатанд байна. Дээрх гэрээнүүдтэй холбоотой гэрээний төсөл болон гэрээнд оруулах өөрчлөлт, сунгалтууд, цаашид хэрэгжих боломжгүй төслүүдийн гэрээг цуцлах болон холбогдох бусад албан бичгүүд зэргийг боловсруулан удирдлагаар хянуулан албажуулж гэрээтэй холбогдох зарим ажлуудыг тухай бүр хийж гүйцэтгэсэн.		
2	Яамны эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих шийдвэр, албан бичгийн төслүүдийн хууль, эрх зүйн үндэслэлийг хянаж зөвлөгөө өгөх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.	Гүйцэтгэлийн явц, хувиар	-	Байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих шийдвэр, албан бичгийн төслүүдийг тухай бүр хянасан байна. /100 хувь/	Шийдвэр, албан бичгийн төслүүдийг холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн хянаж, 83 гадагш чиглэсэн албан бичиг, 30 дотоод бичгийн эрх зүйн үндэслэлийг нягталж албажуулан холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна. Төрийн нарийн бичгийн даргын зардал гаргах тухай тушаал, сайдын шагнах тухай тушаалын төслүүдийг тухай бүр боловсруулж албажуулсан. Гадагш чиглэсэн албан бичигт	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>хуулийн төслүүд болон засгийн газрын тогтоолын төсөл, харьяа байгууллагуудад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлүүлэхээр хандсан бичиг зэрэг хамаарна. Эдгээр гадагш чиглэсэн албан бичигт хууль зүйн үндэслэлийг хангуулан хариу албан бичгийн төслийг боловсруулж дээд шатны удирдлагуудаар хянуулан албажуулж хариуг хүргүүлсэн. Дотоод бичгийн тухайд бусад газар хэлтсүүдээс ирсэн хуулийн төсөл, засгийн газрын тогтоолын төсөл, гэрээ зэрэгт мөн адил хууль зүйн үндэслэлийг судалж тухай бүр холбогдох саналыг хүргүүлсэн. Сайдын тушаал болон Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулагдсан зарим ажлын хэсэгт орж хууль зүйн талаас нь дэмжиж ажилласан. Мөн ЭЗХЯ-наас олгодог шагналыг 2025 оны 02-р сараас 07 дугаар сар хүртэл хариуцан ажилласан. Шагналын тушаалын төсөл бэлтгэх, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Гадаад харилцааны яам зэрэг бусад байгууллага руу чиглэсэн шагнал олгохыг хүссэн албан бичгийн төсөл бэлтгэх, бусад байгууллагаас шагнал гаргуулах тухай албан</p>		
--	--	--	--	--	--	--	--

					бичгээр ирүүлсэн хүсэлтийг судлан холбогдох шагналуудыг гарган ажилласан. Дурдвал харьяа газар болох Оюуны өмчийн газраас "Хууль зүйн албаны тэргүүний ажилтан"-д 6 албан хаагчийг Хууль зүй, дотоодын хэргийн яам руу, Шинжлэх ухааны академиас 2 албан хаагчийг Гадаад харилцааны яам руу, Бусад харьяа байгууллагаас ирүүлсэн 6 албан хаагчийг Төрийн дээд шагналд нэр дэвшүүлэхээр тус тус албан бичгийн төслийг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулан явуулсан байна. Сайдын шагнах тухай 5 тушаалын төслийг боловсруулан хянуулж, албажуулан гаргасан.		
3	Монгол Улсын Засгийн газар болон Эдийн засаг, хөгжлийн яам, сайд, Төрийн нарийн бичгийн даргаас олгосон итгэмжлэлийн хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлж, төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаална.	Гүйцэтгэлийн явц, хувиар	-	Монгол Улсын Засгийн газар, Эдийн засаг, хөгжлийн яамны хууль ёсны эрх ашиг хамгаалагдсан байна. /100 хувь/	Улаан дөл ХХК, Пик девелопмент ХХК, Синапс Мед ХХК-ийн хэргүүдийн шүүхийн маргаанд туслалцаа үзүүлэн ажилласан болно. Нэхэмжлэгч Улаан Дөл ХХК-ийн Монгол Улсын Үндэсний аудитын газарт холбогдох аудитын дүгнэлтийг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлтэй захиргааны хэрэгт гуравдагч этгээдээр оролцсон болно. Пик девелопмент ХХК-ийн нэхэмжлэлтэй Засгийн газар,	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	99%

					<p>Эдийн засаг, хөгжлийн яаманд холбогдох 16 тэрбум төгрөгийн нэхэмжлэлтэй хэргийг Улсын дээд шүүхээс бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон. Мөн "Кью Эс Си" ХХК нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн "Концессын гэрээ цуцлах тухай" 148 дугаар тогтоолыг хүчингүй болгуулахаар маргасан байна. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэхээргүй байна гэж дүгнээд Кью Эс Си ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Тус шүүхийн маргаанд мөн адил туслалцаа үзүүлэн хэргийн хариуцагч талуудтай уулзаж санал дүгнэлт солилцох зэрэг уулзалтад оролцсон. Худалдаа хөгжлийн банкны нэхэмжлэлтэй Дарханы төмөрлөгийн үйлдвэрт холбогдох зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр гаргуулах, тус өр төлбөрөө барагдуулаагүй тохилдолд фидуцийн зүйл болон барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангуулах хэрэгт гуравдагч этгээдээр оролцож байгаа ба тус маргаанд ажиллахаар</p>		
--	--	--	--	--	---	--	--

					бэлдэж байна.		
4	Яамны хэмжээнд байгуулагдаж буй гэрээний төслийг хянах, эрх зүйн үндэслэлийг хангуулах, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэгээр хангах, гэрээний нэгдсэн бүртгэл хөтлөх, архив үүсгэнэ.	Гүйцэтгэлийн явц, хувиар	-	Яамны хэмжээнд байгуулагдаж буй гэрээний төслийг хянах, эрх зүйн үндэслэлийг хангуулах, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэгээр хангах, гэрээний нэгдсэн бүртгэл хөтлөх, дугаар олгох, архив үүсгэх ажиллагааг тухай бүр хийж гүйцэтгэсэн байна. /100 хувь/	Яамны хэмжээнд зарим албан хаагч нартай байгуулагдах хөдөлмөрийн гэрээ болон сэлгэн ажиллах гэрээний төслийг шинээр боловсруулсан ба үйлчилгээ үзүүлэх гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, худалдах, худалдан авах гэрээний төслийг дахин шинэчлэн боловсруулахад ажилласан. Яамны зохион байгуулалтын бусад бүтцийн нэгжүүдээс боловсруулсан үйлчилгээ үзүүлэх гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, худалдах, худалдан авах гэрээ зэргийг хянаж, нэмэлт, өөрчлөлт оруулах саналуудыг тусгаж, боловсруулахад туслалцаа үзүүлсэн. 2025 оны Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд багтсан тавилга тоног төхөөрөмж худалдан авах гэрээний өөрчлөлт, Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгийн хэрэглээний биотехнологийн лабораторийн тоног төхөөрөмж /улаанбаатар, баянзүрх дүүрэг/ төсөл арга хэмжээний багц-1 "биотехнологийн төвийн молекул биологи, генетикийн суурь лабораторийн багаж тоног төхөөрөмж худалдан авах гэрээний төсөл болон	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					бусад холбоглох мэдээллүүдийг боловсруулсан. Мөн яамны дэргэдэх Ахмадын хороотой хамтран, Хамтран ажиллах гэрээ, бусад хэрэгцээ шаардлагаар байгуулагдаж буй худалдах, худалдан авах, үйлчилгээ үзүүлэх гэрээ зэргийг тухай бүр байгуулсан. 2023 оны 10 боть гэрээ, 2024 оны 6 боть гэрээ, боть тус бүрт 250 хуудас байхаар гэрээний товьёг үйлдэн архив үүсгэж архивын ажилтанд хүлээлгэн өгсөн ба 2025 оны гэрээг архивт хүлээлгэн өгөхөөр бэлдэж байна.		
5	Салбарын хуулийн төсөл боловсруулах, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судалж арилгах, хууль тогтоомжийн уялдаа холбоог хангана.	Гүйцэтгэлийн явц, хувиар	-	Салбарын хууль давхардал, хийдэл, зөрчлийг судалж арилгах, хууль тогтоомжийн уялдаа холбоо сайжирсан байна. /100 хувь/	"Эдийн засаг, хөгжлийн яамны албан хаагчдад орон сууцны дэмжлэг үзүүлэх тухай журам"-ын төслийг боловсруулах, төсөлд хамрагдах зарим жишиг өргөдлийн загвар, албан хаагчтай байгуулах гэрээ зэргийг боловсруулахад ажилласан. "Улаанбаатар хотын худалдааны танхимын ерөнхийлөгч Ц.Баатарсайханаас ирүүлсэн Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	99%

					<p>авах тухай хууль, Газрын тухай хуулийн төслүүдэд өгсөн саналыг судалж, агуулгаар ангилан хуулийн төсөлд тусгагдах боломжтой саналуудыг нэгтгэн удирдлагад танилцуулсан болно. Мөн Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн ажлын тайланг боловсруулахад туслалцаа үзүүлсэн. Яамны "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг шинэчлэн батлуулахаар яамны бусад газар хэлтсээс саналуудыг авч Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль зэрэгт нийцүүлэн нэгтгэн агуулгаар ангилж саналын товъёог үйлдсэн. Одоогоор төслийг удирдлагад танилцуулах шатанд байна. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаас Бүсийн зөвлөлийн дарга болон зарим аймгийн Засаг дарга нараас гаргасан саналын дагуу аймаг, орон нутагт тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэх төлөвлөгөөг баталсан. Тус төлөвлөгөөний 36 дахь хэсэгт "Мэргэжлийн хяналтын газрын үйл ажиллагааг сэргээх, дахин</p>		
--	--	--	--	--	--	--	--

					байгуулах боломжийг судалж, санал боловсруулах" асуудлыг Эдийн засаг, хөгжлийн яаманд даалгасан. Энэ хүрээнд тухайн асуудлаар холбогдох судалгаа мэдээллийг хийсэн. Үүнтэй холбогдуулаад "Төрийн хяналт шалгалтын тухай хууль"-ийн хүрээнд гүйцэтгэсэн судалгаануудыг уншиж тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэх талаар судалж тайлан бичсэн болно.		
6	Хүний эрх, жендертэй холбоотой сургалт, хэлэлцүүлэгт хамрагдах, энэ талаарх бусад ажлыг хийж гүйцэтгэсэн байна.	Гүйцэтгэлийн явц, хувиар	-	Хүний эрх, жендертэй холбоотой ажлыг хийж гүйцэтгэсэн байна. /100%/	Хүний эрх, жендертэй холбоотой албан бичгүүдэд хариу өгч эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулан хариу илгээн ажиллаж байна. Монгол улсын хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжидэд Хүний эрхийн Үндэсний Комиссын 01/01 дугаартай "Хүний эрхийн боловсролын арга зүй" симпозиумын зөвлөмжийн хэрэгжилтийг яамны хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн болон хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн үйл ажиллагааг хүргүүлсэн байна. Монгол Улсын Хууль Зүй Дотоод хэргийн сайдын 2024 оны А/130 тушаалаар "Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний II хөтөлбөр"-ийн төсөл боловсруулах ажлын	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>хэсгийг байгуулсан. Энэхүү үйл ажиллагаатай холбоотой яаманд зохион байгуулагдаж буй сургалт, уулзалтад оролцсон болно. УИХ-ын гишүүн Х.Баасанжаргал, ЭЗХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү болон бусад холбогдох гишүүд Хүний эрхийн үндэсний хөтөлбөрийг өргөн барих явцын талаар Эдийн засаг, хөгжлийн яамны 9 давхарт хуралдсан болно. ХЭҮК-оос эрэгтэйчүүдийн жендэрийн асуудлыг анх хөндөж "Эрэгтэйчүүдийн жендэрийн эрх тэгш байдал" сэдэвт бодлогын судалгааны ажлыг "Орон нутгийн хөгжлийн бодлого судлалын төв"-тэй хамтран хийж байна. Энэ хүрээнд судалгаанд шаардлагатай мэдээлэл цуглуулах, санал солилцох зорилгоор уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт оролцож санал дүгнэлтээ тусгасан болно. ХЭҮК-оос 2025 оны Хүний эрхийн Үндэсний Форумыг "Хамтын эрх-хариуцлага" сэдвийн хүрээнд нэгдсэн хуралдаан болон "Хүний эрх ба уур амьсгалын өөрчлөлт ногоон хөгжил", "Хүний эрх ба хот төлөвлөлт", "Хүний эрх ба бизнес" салбар</p>		
--	--	--	--	--	--	--	--

					хуралдаантайгаар зохион байгуулах гэж байгаа ба тус хуралдаанд оролцохоор бэлдэж байна.		
--	--	--	--	--	---	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Өөрөө хариуцсан ажлын хүрээнд мэдлэг мэргэжлээ дээшлүүлсэн байх.	Сургалтад хамрагдсан байх	-	Сургалтад хамрагдсан байх	Удирдлагын академийн Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад сууж 40 цагийн хичээлийг үзсэн болно. Үнэмлэхийн дугаар М224. Хариуцсан ажлын хүрээнд дараах хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцож санал, дүгнэлтээ тусгасан байна. 1. Гэрийн бүлийн тухай хууль/шинэчилсэн найруулга/-ын төсөл, 2. Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн танилцуулга, 3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд, нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, хэлэлцүүлэг. 4.Гэр бүл, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас боловсруулж буй Гэр бүлийн тухай анхдагч хуулийн төслийн хэлэлцүүлэг, 5.	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг, 6.Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт тухай бүр оролцсон. Мөн яамнаас зохион байгуулсан Хуулийн төсөл боловсруулагчийн арга зүйн сургалтад хамрагдаж багц хичээлүүдийг судалж төгссөн.		
2	Хариуцсан ажлын хүрээнд хэлэлцүүлэг, семинар, уулзалт, мэдээллийн цагт оролцсон байх.	Сургалтад хамрагдсан байх.	-	Сургалтад хамрагдсан байх.	ХЭҮК-оос зохион байгуулсан Эрэгтэйчүүдийн жендэрийн тэгш байдлын тулгамдсан асуудлыг тодорхойлох, энэ талаар авч хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ, зорилтын талаар салбарын мэргэжилтэн, шинжээч, албан хаагчидтай санал солилцох уулзалт, хэлэлцүүлэг, "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн форум" хэлэлцүүлэг, 2026 оны төсвийн төслийн хэлэлцүүлэгт тус бүр хамрагдсан. Мөн Яамнаас зохион байгуулдаг Мэдээллийн цагт тогтмол оролцсон. Үүнд: Олон ишт ба ёс зүйн эдийн засаг: Антропологийн чиг хандлага сургалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн талаарх сургалт, Зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний тухай сургалт, "Ажил, амьдралын тэнцвэр" сургалт, Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай" сургалт /цахимаар оролцсон/, "Хиймэл оюун ба хэрэглээ, түүнийг хэрхэн үр дүнтэй ашиглах", Монгол Улсад тогтвортой дэд бүтцийн хөгжил болон ногоон санхүүжилт, "Эдийн засгийн албаны үүсэл, хөгжлийн түүх, Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн чадавх, судалгааны үр дүнг	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

				үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломж", Healthy is the new cool сэдвээр хэлэлцүүлэг, семинарт идэвхтэй хамрагдсан.		
--	--	--	--	--	--	--

ХЯНАСАН:

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Дашням Ариунбилэг /...../

Огноо: 2025.12.15.

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн, Бүрэнбаатар Лхамжав /...../

Огноо: 2025.12.15.

